Захирамж хүчингүй болгох тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.2, 29.3, Монгол Улсын Хууль зүй, дотоод хэргийн яамны 2018 оны 01 дүгээр сарын 31-ний өдрийн 1-4/596 дугаартай албан бичгийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хууль, Зөрчил шалган шийдвэрлэх тухай хууль хэрэгжиж эхэлсэнтэй холбогдуулан дүүргийн Засаг даргын 2017 оны 04 дүгээр сарын 14-ний өдрийн А/174 дүгээр "Үнэлгээний комисс байгуулах тухай" захирамжийг хүчингүй болгосугай.

2. Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Эдийн засаг, худалдаа үйлчилгээ, тохижилт, нийтийн аж ахуйн асуудал хариуцсан төслийн удирдагч /Э.Батбилэг/-д даалгасугай.

ЗАСАГ ДАРГА С.ОДОНТУЯА

D:\ 2018 он\Захирамжлалын ББ\Захирамж.docx

1160200113

БАЯНГОЛ ДҮҮРГИЙН
ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2018 оны 02 сарын 14 өдөр Дугаар А/58 Улаанбаатар хот

"Хүүхдийн урлагийн их наадам"
арга хэмжээ зохион байгуулах тухай

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.2, Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.1.17, Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газрын даргын 2018 оны 02 дугаар сарын 01-ний өдрийн А/20 дугаар тушаалыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Хүүхэд өсвөр үеийнхэнд Монгол үндэстний урлагийн их өв санг түгээн дэлгэрүүлэх, эзэмшүүлэх, өвлүүлэх, сурталчлах, тэдний авьяас чадварыг хөгжүүлэх, харилцан суралцах, хамтран уран бүтээл туурвих Монгол Улсаас ЮНЕСКО-д бүртгүүлсэн соёлын өвийг хүүхэд багачуудад өвлүүлж, Монгол үндэстний соёл урлаг, зан заншлаараа бахархах үзлийг төлөвшүүлэх, соёлын солилцоог хөгжүүлэх зорилгоор "Хүүхдийн урлагийн их наадам"-ыг дүүргийн хэмжээнд зохион байгуулсугай.

2. Арга хэмжээ зохион байгуулах Ажлын хэсгийн бүрэлдэхүүнийг нэгдүгээр, удирдамжийг хоёрдугаар, шаардагдах төсвийг гуравдугаар хавсралтаар тус тус баталсугай.

3. Арга хэмжээнд шаардагдах төсвийг холбогдох хууль тогтоомжийн хүрээнд шийдвэрлэхийг Тамгын газар /Д.Дэлгэрмаа/-т зөвшөөрсүгэй.

4. Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Засаг даргын орлогч Г.Нарангэрэл/-д даалгасугай.

ЗАСАГ ДАРГА С.ОДОНТУЯА

D:\ 2018 он\Захирамжлалын ББ\Захирамж.docx

1160200122

Баянгол дүүргийн Засаг даргын
2018 оны ...02... дугаар сарын ...14... –ны өдрийн
...А/58... дугаар захирамжийн нэгдүгээр хавсралт

"ХҮҮХДИЙН УРЛАГИЙН ИХ НААДАМ"
АРГА ХЭМЖЭЭ ЗОХИОН БАЙГУУЛАХ
АЖЛЫН ХЭСГИЙН БҮРЭЛДЭХҮҮН

Ажлын хэсгийн дарга	Г.Нарангэрэл	Засаг даргын орлогч
Нарийн бичиг	А.Ганболд	Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн хэлтсийн дарга
Гишүүд	А.Одонтунгалагтуул	Нийгмийн хөгжлийн хэлтсийн дарга
	Л.Жаргал	Боловсролын хэлтсийн дарга
	Д.Дэлгэрбат	Хүүхэд, залуучуудын соёлын ордон ОНӨТҮГ-ын дарга

Баянгол дүүргийн Засаг даргын
2018 оны 02 дугаар сарын 14 -ны өдрийн
А/57 дугаар захирамжийн хоёрдугаар хавсралт

ХҮҮХДИЙН УРЛАГИЙН НААДМЫН УДИРДАМЖ

Үндэслэл:

Монгол Улсын Засгийн газрын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн 3.4.5 дахь зорилт Хүүхдийн хүмүүжил, төлөвшилд үндэсний өв уламжлал, урлаг соёлоор дамжуулан эерэгээр нөлөөлөх бодлого хэрэгжүүлэх, Хүүхдийн хөгжил хамгааллын үндэсний хөтөлбөрийн "Хүүхэд бүрийг хөгжүүлэх таатай орчныг бүрдүүлж, хүүхдийн авьяас чадварыг нээн хөгжүүлэх гэсэн зорилтыг үндэслэн "Хүүхдийн урлагийн их наадмыг" зохион байгуулж байна.

Нэг. Наадмын зорилго

1. Хүүхэд өсвөр үеийнхэнд Монгол үндэстний урлагийн их өв санг түгээн дэлгэрүүлэх, эзэмшүүлэх, өвлүүлэх, сурталчилах, тэдний авьяас чадварыг хөгжүүлэх, харилцан суралцах, хамтран уран бүтээл туурвих Монгол Улсаас ЮНЕСКО-д бүртгүүлсэн соёлын өвийг хүүхэд багачуудад өвлүүлж Монгол үндэстний соёл урлаг, зан заншлаараа бахархах үзлийг төлөвшүүлэх, соёлын солилцоог хөгжүүлэхэд оршино.

Хоёр. Хамрах хүрээ

2. Дүүргийн төрийн болон төрийн бус өмчийн ерөнхий боловсролын сургуулийн сурагчид байна.

Гурав. Урлагийн наадмын төрөл

3.1. Ардын дуу /уртын дуу, бэсрэг уртын дуу, богино дуу/
3.2. Бүжиг /Бие биелэгээ, уран нугаралт, орчин үеийн бүжиг/
3.3. Язгуур урлаг / Хөөмий, Тууль, архираа, эсгэрээ/
3.4. Орчин үеийн дуу /Эстрад, зохиол/
3.5. Хөгжим /ардын хөгжим, сонгодог хөгжим/
3.6. Төрөл тус бүр дээр сургууль бүрээс нэг, нэг хүүхэд оролцоно.

Дөрөв. Шалгаруулах журам

4.1. Хүүхдийн урлагийн их наадмыг 2 үе шаттайгаар зохион байгуулна.
4.1.1. Нэгдүгээр үе шат: Дүүргийн хэмжээнд урлагийн бага наадам зохион байгуулж шилдэг хүүхдүүдийг шалгаруулна.
4.1.2. Хоёрдугаар үе шат: Хоёрдугаар шатанд шалгарсан шилдэг хүүхдүүд Нийслэлийн хэмжээнд "Хүүхдийн урлагийн их наадам"-д оролцоно.

Тав. Хугацаа

5.1. Дүүргийн хэмжээний шалгаруулалт: 2018 оны 03 дугаар сарын 09-ний өдөр зохион байгуулагдана.

Зургаа.Наадмын зохион байгуулалт, хамтран ажиллах байгууллага

6.1. Ажлын хэсэгт багтсан дараах байгууллагууд ерөнхий зохион байгуулалтыг хариуцан ажиллана.
Нийгмийн хөгжлийн хэлтэс, Боловсролын хэлтэс, Гэр бүл, хүүхэд залуучуудын хөгжлийн хэлтэс, Хүүхэд, залуучуудын соёлын ордон, ЕБС-иуд

6.1.1. "Хүүхдийн урлагийн их наадам"-д оролцогчдыг тодруулахдаа дүүргийн хэмжээнд уралдааны хэлбэрээр зохион байгуулах бөгөөд түүнд шаардагдах төсвийг орон нутаг өөрсдөө бие даан шийдвэрлэнэ.

6.1.2."Хүүхдийн урлагийн их наадам"-ын I шатны шалгаруулалтын тайланг 2018 оны 05 сарын 20-ны дотор Хүүхдийн хөгжил хамгааллын газарт албан бичгийн хамтаар хүргүүлэхийг Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн хэлтэс хариуцна.

Долоо.Шагнал урамшуулал

7.1. Төрөл тус бүр дээр 3 байр эзлүүлэх ба тус бүр өргөмжлөл, мөнгөн шагналын хамт дагалдана.

Дэлгэрэнгүй мэдээллийг:Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн хэлтэс
76000067, 99754430,

Баянгол дүүргийн Засаг даргын
2018 оны 02 дугаар сарын 14 -ны өдрийн
А/158 дугаар захирамжийн гуравдугаар хавсралт

"ХҮҮХДИЙН УРЛАГИЙН ИХ НААДАМ"
АРГА ХЭМЖЭЭ ЗОХИОН БАЙГУУЛАХАД ШААРДАГДАХ ЗАРДЛЫН ТӨСӨВ

№	Нэр	Нэгж үнэ	тоо/ширхэг	Нийт үнэ
1	Өргөмжлөл	30,000	15	450,000
2	1-р байрны шагнал /5 төрөл/	150,000	5	750,000
3	2-р байрны шагнал /5 төрөл/	100,000	5	500,000
4	3-р байрны шагнал /5 төрөл/	80,000	5	400,000
5	Шүүгчийн хөлс /5 төрөл/	50,000	3	150,000
5	Хулдаасан хэвлэл	6,500	3x4=12м^2	78,000
	Нийт		2,328,000	

БАЯНГОЛ ДҮҮРГИЙН
ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2017 оны 02 сарын 19 өдөр Дугаар А/59 Улаанбаатар хот

"Мандал" сууц өмчлөгчдийн холбоог
бүртгэж, гэрчилгээ олгох тухай

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1.6.л, 29.2,Сууц өмчлөгчдийн холбооны эрх зүйн байдал, нийтийн зориулалттай орон сууцны байшингийн дундын өмчлөлийн эд хөрөнгийн тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.1.1 дэх заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Баянгол дүүргийн 1 дүгээр хорооны нутаг дэвсгэрт байршилтай 52 дугаар байрны оршин суугчдын 2017 оны 12 дугаар сарын 17-ны өдрийн бүх гишүүдийн хурлаар "Мандал" холбоо байгуулсан тухай шийдвэр, холбогдох материалыг үндэслэн дүүргийн сууц өмчлөгчдийн холбоодын бүртгэлд бүртгэж, гэрчилгээг олгосугай.

2. Нийтийн зориулалттай орон сууцны байшингийн дундын өмчлөлийн эд хөрөнгийн ашиглалтын хэвийн байдлыг хангах, сууц өмчлөгчдийн эрх, ашиг сонирхлыг хамгаалах, дундын өмчлөлийн эд хөрөнгийн эзэмшил, ашиглалт, хамгаалалтыг эрхлэн хариуцах, биелэлтийг ханган ажиллахыг "Мандал" сууц өмчлөгчдийн холбоонд даалгасугай.

3. Дүүргийн сууц өмчлөгчдийн холбоодын бүртгэлд бүртгэх, захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Тохижилт, нийтийн аж ахуйн хэлтэс /Б.Одгэрэл/-т даалгасугай.

ЗАСАГ ДАРГА С.ОДОНТУЯА

D:\ 2018 он\Захирамжлалын ББ\Захирамж.docx

1160200132

БАЯНГОЛ ДҮҮРГИЙН
ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2018 оны 02 сарын 19 өдөр Дугаар А/60 Улаанбаатар хот

"Мөнгөн Улаанбаатар" өвлийн спорт
наадамд оролцох тухай

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1.5.а, 29.2, нийслэлийн Засаг даргын 2018 оны А/23 дугаар захирамж, Нийтийн биеийн тамир, спортын хорооны 02/34 дүгээр албан бичиг, удирдамжийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Нийслэлийн төр захиргааны байгууллагын ажилтан, албан хаагчдын "Мөнгөн Улаанбаатар" өвлийн спорт наадмын "Цасны баяр" арга хэмжээнд дүүргийн харьяа хэлтэс, албадыг зохион байгуулалттай оролцуулсугай.

2. Өдөрлөгт оролцох удирдамжийг нэгдүгээр, оролцох багийн бүрэлдэхүүнийг хоёрдугаар хавсралтаар тус тус баталсугай.

3. Тус өвлийн өдөрлөгт нийт ажилтан албан хаагчдыг бүрэн хамруулж, нийтийн биеийн тамир, спортыг сурталчлан ажиллахыг Нийгмийн хөгжлийн хэлтэс, /А.Одонтунгалагтуул/, Биеийн тамир, спортын хороо /Б.Дамба/-нд тус тус үүрэг болгосугай.

4. Арга хэмжээнд шаардагдах төсвийг хууль тогтоомжийн хүрээнд баталж, холбогдох зардлын данснаас гаргахыг Тамгын газар /Д.Дэлгэрмаа/-т зөвшөөрсүгэй.

5. Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж, үр дүнг тооцож ажиллахыг Засаг даргын орлогч Г.Нарангэрэлд даалгасугай.

ЗАСАГ ДАРГА С.ОДОНТУЯА

D:\ 2018 он\Захирамжлалын ББ\Захирамж.docx

1160200128

Баянгол дүүргийн Засаг даргын
2018 оны 02 дугаар сарын 19-ны өдрийн
А/60 дугаар захирамжийн нэгдүгээр хавсралт

"МӨНГӨН УЛААНБААТАР " ӨВЛИЙН СПОРТ
ӨДӨРЛӨГТ ОРОЛЦОХ УДИРДАМЖ

НЭГ. ЗОРИЛГО

Монгол Улсын "Биеийн тамир, спортын тухай" хууль, Засгийн газрын 2009 оны 05 дугаар тогтоол, "Амьдралын буруу хэвшлээс үүдэлтэй өвчнөөс сэргийлэх, хянах үндэсний хөтөлбөр"-ийн хэрэгжилтийн хангах,"Эрүүл Баянгол дүүрэг" хөтөлбөрийн хэрэгжилт өвлийн спортыг сурталчлах, ажилтан албан хаагчдыг нийтийн биеийн тамир спортын үйл ажиллагаанд татан оролцуулах, бие бялдрыг чийрэгжүүлэх, хөдөлгөөний хомсдолоос урьдчилан сэргийлэх, эрүүл, цэвэр агаарт амралт чөлөөт цагийг зөв зохистой өнгөрүүлэхэд оршино.

ХОЁР. ЗОХИОН БАЙГУУЛАХ ГАЗАР, ХУГАЦАА

2018 оны 02 дугаар сарын 24-ны өдөр 10.00-17.00 цагт "Хандгайт"-ын "Янзага" зусланд зохион байгуулагдана.

ГУРАВ. ХАМТРАН ЗОХИОН БАЙГУУЛАГЧ

1. Баянгол дүүргийн Засаг даргын Тамгын газар
2. Баянгол дүүргийн Биеийн тамир, спортын хороо
3. Баянгол дүүргийн Боловсролын хэлтэс
4. Баянгол дүүргийн Онцгой байдлын хэлтэс

ДӨРӨВ. ХАМРАХ ХҮРЭЭ

1. Баянгол дүүргийн Засаг даргын Тамгын газар
2. Баянгол дүүргийн хороодын ажлын алба
3. Баянгол дүүргийн Засаг даргын Тамгын газрын харьяа хэлтэс, алба

ТАВ. ТЭМЦЭЭН, ДЭГ ЖУРАМ, ЗОХИОН БАЙГУУЛАЛТ

1. "Олс таталт" тэмцээн - байгууллага бүрээс 4 эрэгтэй, 2 эмэгтэй тамирчин
2. "Цасны сумо" тэмцээн - байгууллага бүрээс 1 эрэгтэй, 1 эмэгтэй тамирчин
3. "Хөгжилтэй буухиа" тэмцээн - байгууллага бүрээс 3 эрэгтэй , 2 эмэгтэй тамирчин
4. "Цасны гар бөмбөг" тэмцээн - байгууллага бүрээс 2 эрэгтэй, 2 эмэгтэй тамирчин

Харьяа хэлтэс, албадын баг тамирчид тэмцээнд спортын хувцастай, дэг журамтай цагийн хуваарийн дагуу оролцоно.

ЗУРГАА. ЗОХИОН БАЙГУУЛАГДАХ АРГА ХЭМЖЭЭ, ХӨТӨЛБӨР

№	Хугацаа	Үндсэн үйл ажиллагаа	Хариуцах хэлтэс алба
1	09:00-10:00	Бэлтгэл хангах /Байгууллага бүр өөрийн туг, эмблем, нэрийн самбартай оролцоно/ Урьдчилан оноогдсон талбайд гэр, майхан зэргийг барьж байрласан байна.	Дүүргийн Засаг даргын Тамгын газар Аж ахуйн алба Харьяа хэлтэс, албад
		Баянгол дүүргийн оноогдсон талбайг чимэх, тусгаарлах	Боловсролын хэлтэс Л.Жаргал Биеийн тамир спорт хороо Б.Дамба
2	10:00	"Пенчан 2018 – Өвлийн олимп" цасан хотхон байгуулна.	Боловсролын хэлтэс Л.Жаргал Онцгой байдлын хэлтэс А.Батмөнх
3	10:10	Цасан дээрх бүжгийн тэмцээнд оролцох албан хаагчид бүртгүүлнэ. /Байгууллага тус бүрээс 1 хос оролцоно/	Хөдөлмөр, нийгмийн халамж үйлчилгээний хэлтэс Э.Мэндбаяр
4	11:00	Нийслэлийн өвлийн өдөрлөгийн нээлтийн ажиллагаа /Байгууллага бүр өөрийн туг далбаагаа барьж хамт олноороо жагсаж нээлтэнд оролцоно/	Биеийн тамир спортын хороо Б.Дамба Харьяа хэлтэс албад
5	11:30-12:00	Айзамт гимнастик Байгууллага хамт олны дасгал хөдөлгөөн	Биеийн тамир спортын хороо Б.Дамба
6	12:00	Баянгол дүүргийн өвлийн спорт өдөрлөг нээлт	Засаг даргын Тамгын газар Биеийн тамир спортын хороо Б.Дамба
7	12:15-16:00	Биеийн тамир, спортын тэмцээн явагдана. 1. "Олс таталт" тэмцээн 2. "Цасны сумо" тэмцээн 3. "Хөгжилтэй буухиа" тэмцээн 4. "Цасны гар бөмбөг" тэмцээн	Биеийн тамир спортын хороо Б.Дамба
8	13:00-14:00	Үдийн цай Байгууллага бүр эрүүл хүнсээр үдийн цай, хоол бэлтгэн оролцоно.	Хүнс худалдаа үйлчилгээний хэлтэс Харьяа хэлтэс алба Хороод
9	16:00	Тэмцээний шагнал гардуулах үйл ажиллагаа	Биеийн тамир спортын хороо Б.Дамба
10	17:00	Хаалтын үйл ажиллагаа Улаанбаатар хотруу буцна.	Биеийн тамир спортын хороо Б.Дамба Харьяа хэлтэс албад

ДОЛОО. ШАГНАЛ УРАМШУУЛАЛ

Тэмцээн тус бүрт эхний 3 байрыг шалгаруулж өргөмжлөл, мөнгөн шагналаар шагнаж урамшуулахаас гадна, байгууллагын нэгдсэн дүнгээр эхний 3 байрыг шалгаруулж өргөмжлөл, мөнгөн шагналаар шагнаж, урамшуулна.

НАЙМ. БУСАД

1. Хэлтэс, алба, хороод өөрийн лого, туг дарцагтай байх ба жигд хувцасласан байна.
2. Ажилтан, албан хаагчид хөнгөн цай хоол хүнс болон аялалын жижиг ширээ, сандал гэх мэт хувийн бэлтгэлийг өөрсдөө бэлтгэсэн байна.
3. Согтууруулах ундаа хэрэглэхийг хориглоно.
4. Байрлаж үдэлсэн газраа хог хаягдал хаяхыг хориглоно.

Холбоо барих утас: Нийгмийн хөгжлийн хэлтэс 11365574, 88049014

Баянгол дүүргийн Засаг даргын
2018 оны 02 дугаар сарын 12-ны өдрийн
А/60 дугаар захирамжийн хоёрдугаар хавсралт

"МӨНГӨН УЛААНБААТАР" ӨВЛИЙН ӨДӨРЛӨГТ ОРОЛЦОХ БАГИЙН БҮРЭЛДЭХҮҮН

1. Засаг даргын Тамгын газар
2. Хороодын ажлын алба
3. Эрүүл мэнд, нийгмийн даатгалын хэлтэс
4. Хөдөлмөр, халамж үйлчилгээний хэлтэс
5. Мэргэжлийн хяналтын хэлтэс
6. Татварын хэлтэс
7. Онцгой байдлын хэлтэс, Гэр бүл, хүүхэд залуучуудын хөгжлийн хэлтэс, Хүүхэд залуучуулын соёлын ордон, Баянгол Хүүхдийн Зуслан, Баянгол Агропарк, Усан спорт сургалтын төв
8. Эрүүл мэндийн нэгдэл
9. Цагдаагийн нэгдүгээр хэлтэс
10. Цагдаагийн хоёрдугаар хэлтэс
11. Замын цагдаагийн тасаг, Насан туршийн боловсролын төв, Баянгол дүүргийн Жижиг дунд үйлдвэрлэлийг дэмжих төв, Гэр бүл ёслолын ордон
12. Бүртгэлийн хэлтэс, Худалдан авах ажиллагааны алба, Статистикийн хэлтэс
13. Биеийн тамир спортын хороо, Дотоод аудитын алба, Газрын алба, Боловсролын хэлтэс, Ахмадын хороо
14. Баянгол Шинэ Өргөө ОНӨААТҮГ

БАЯНГОЛ ДҮҮРГИЙН
ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2018 оны 02 сарын 20 өдөр Дугаар А/61 Улаанбаатар хот

Гамшгаас хамгаалах бэлэн байдлын үзлэг
зохион байгуулах тухай

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.2, Гамшгаас хамгаалах тухай хуулийн 32 дугаар зүйлийн 32.1.1, 32.1.2, 32.1.8, Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.3 дахь хэсэг, Сангийн сайдын 2012 оны А/239 дүгээр тушаал, нийслэлийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2015 оны 134 дүгээр тогтоол, нийслэлийн Засаг даргын 2018 оны А/41 дүгээр захирамжийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Болзошгүй гамшгийн аюулаас хүн, мал амьтан, эд хөрөнгө, хүрээлэн байгаа орчныг урьдчилан сэргийлэх, аврах, хор уршгийг арилгах, хойшлуулшгүй сэргээн босгох үйл ажиллагаанд иргэн, аж ахуйн нэгж, байгууллагын томилгоот бүрэлдэхүүнийг сурган дадлагажуулах, гамшгийн үеийн хүч хэрэгслийн харилцан ажиллагааг сайжруулах, гамшгаас хамгаалах бэлтгэл бэлэн байдалд шалган туслах үзлэгт хамрагдах 100 аж ахуйн нэгж, байгууллагын нэрсийг нэгдүгээр, шаардагдах зардлыг хоёрдугаар, удирдамжийг гуравдугаар хавсралтаар тус тус баталсугай.

2. Бэлэн байдлын үзлэг шалгалтыг явуулахад шаардагдах зардалд 4,649,880 /дөрвөн сая зургаан зуун дөчин есөн мянга найман зуун наян мянга/ төгрөгийг Засаг даргын нөөц хөрөнгөөс гаргахыг Засаг даргын Тамгын газрын Ахлах нягтлан бодогч /Б.Хонгорзул/-д зөвшөөрсүгэй.

3. Бэлэн байдлын үзлэгт шаардагдах бэлтгэл ажлыг хангуулж ажиллахыг холбогдох байгууллагын дарга, захирал нарт үүрэг болгосугай.

4. Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж, үр дүнг тооцож, танилцуулж ажиллахыг Онцгой байдлын хэлтэс /А.Батмөнх/-т даалгасугай.

ЗАСАГ ДАРГА С.ОДОНТУЯА

D:\ 2018 он\Захирамжлалын ББ\Захирамж.docx

1160200176

Баянгол дүүргийн Засаг даргын
2018 оны 02 дугаар сарын 20-ны өдрийн
А/61 дугаар захирамжийн нэгдүгээр хавсралт

НИЙСЛЭЛИЙН ЗАСАГ ДАРГЫН НЭРЭМЖИТ ГАМШГААС ХАМГААЛАХ БЭЛЭН БАЙДЛЫН ҮЗЛЭГТ ХАМРАГДАХ БАЙГУУЛЛАГЫН НЭРС

д/д	Аж ахуйн нэгж, байгууллагын нэр
Нэг. Төрийн захиргааны байгууллагууд	
1	Дүүргийн Засаг даргын Тамгын газар
2	УБЦТСХК Баянгол хэрэглэгчдэд үйлчлэх төв
3	Хөдөлмөр, нийгмийн халамж үйлчилгээний хэлтэс
4	Мэргэжлийн хяналтын хэлтэс
5	ТЭЦ-2 ТӨХК
6	ТЭЦ-4 ТӨХК
7	Улаанбаатар дулааны сүлжээ ХК
8	Төмөр замын удидах газар
9	Нийслэлийн Мал эмнэлгийн газар
10	Усан спорт сургалтын төв
Хоёр. Үндэсний аюулгүй байдлыг хангах тусгайлсан чиг үүрэг бүхий байгууллагууд	
11	Цагдаагийн нэгдүгээр хэлтэс
12	Цагдаагийн хоёрдугаар хэлтэс
13	Замын цагдаагийн хэлтэс
14	ШШГЕГ-ын хорих 461-р анги
15	Хилийн цэргийн 0164-р анги
16	Нийслэлийн аврах анги
17	ЦЕГ авто бааз
Гурав. Эрүүл мэндийн байгууллагууд	
18	Гэмтэл согог судлалын үндэсний төв
19	Эрүүл мэндийн төв
20	Ачтан эмнэлэг
21	Гуравдугаар эмнэлэг
22	Эх хүүхдийн эрүүл мэндийн үндэсний төв
23	Нялхсын клиник сувилал
24	Наркологи эмнэлэг
25	Төмөр замын эмнэлэг
26	Баянгол эмнэлэг
27	Гарьд манлай эмнэлэг
28	Монос агуулах
29	Гурван гал эмнэлэг
30	Топаз эмнэлэг
Дөрөв. Нутгийн захиргааны байгууллагууд	
31	2 дугаар хороо
32	4 дүгээр хороо
33	16 дугаар хороо
34	20 дугаар хороо

Дөрөв. Орон сууцны конторууд		
35	Баруун түгээх төв	
36	Төв түгээх төв	
37	Хэрэглэгчдэд үйлчлэх төв-9	
38	Хэрэглэгчдэд үйлчлэх төв-11	
39	Хэрэглэгчдэд үйлчлэх төв-12	
40	Хэрэглэгчдэд үйлчлэх төв-13	
41	Хэрэглэгчдэд үйлчлэх төв-14	
Тав. Үзвэр олон нийтийн байгууллагууд		
42	Улаанбаатар палас	
43	Монголын үйлдэрчний эвлэлийн соёлын төв ордон	
44	Өргөө кино театр	
45	Монголын үндэсний олон нийтийн радио телевиз	
46	Улаанбаатар телевиз	
47	Баянгол шинэ өргөө ОНӨААТҮГ	
48	Гандантэгчилэн хийд	
Зургаа. Боловсролын байгууллагууд		
Их дээд сургууль		
49	Тээврийн дээд сургууль	
50	Барилгын технологийн коллеж	
51	Техник технологийн дээд сургууль	
52	Олон улсын эдийн засаг бизнесийн дээд сургууль	
53	Сувилахуйн сургууль	
54	Мон-алтиус дээд сургууль	
55	Хүрээ дээд сургууль	
Ерөнхий боловсролын сургууль		
56	13 дугаар сургууль	
57	19 дүгээр сургууль	
58	20 дугаар сургууль	
59	43 дугаар сургууль	
60	47 дугаар сургууль	
61	96 дугаар сургууль	
62	38 дугаар сургууль	
63	73 дугаар сургууль	
Цэцэрлэг		
64	162 дугаар цэцэрлэг	
65	242 дугаар цэцэрлэг	
66	157 дугаар цэцэрлэг	
67	97 дугаар цэцэрлэг	
68	76 дугаар цээрлэг	
Долоо. Аж ахуйн нэгж, байгууллагууд		
69	Трейнд мебель ХХК	
70	Хүн-од ХХК	
71	Трансвест монголиа ХХК	
72	Эрдэм транс ХХК	
73	Тэнүүн огоо ХХК	
74	МТС агро	
75	Кёкүшю тауэр	
76	НОЦ ХХК	

77	Наран булаг ХХК	
78	Ноён уул ХХК	
79	Монгол тамхи со ХХК	
80	Агь ХК	
81	Мах маркет	
82	Хэт хүч моторс	
83	Улаанбаатар бүк	
84	Вагнер ази	
85	Сод агуулах	
86	Гранд плаза	
87	Монос агуулах	
	Найм. Зочид буудал	
88	Гранд хилл	
89	Рамада	
90	Наранбулаг	
	Ес. Худалдааны төв, зах	
91	Хар хорин худалдааны төв	
92	Номин өргөө салбар	
93	Номин андууд салбар	
94	Номин 10 дугаар хороолол салбар	
95	Биг худалдааны төв	
96	И март худалдааны төв	
97	Ханбүргэдэй худалдааны төв	
98	Старс худалдааны төв	
	10. Шатахуун түгээх станцууд	
99	"Сод монгол групп" ХХК УБНХГ	
100	ШТС-14	

Баянгол дүүргийн Засаг даргын
2018 оны 02 дугаар сарын 20-ны өдрийн
А/61 дугаар захирамжийн хоёрдугаар хавсралт

ГАМШГААС ХАМГААЛАХ БЭЛЭН БАЙДЛЫН ҮЗЛЭХ ЯВУУЛАХ АЛБАН ХААГЧДАД ШААРДАГДАХ ХООЛ ХҮНС, БИЧИГ ХЭРЭГСЭЛ, ЗАМЫН ЗАРДЛЫН ТООЦОО

Д/Д		Шаардагдах материал	Зориулалт	Хэмжих нэгж	Тоо хэмжээ	Нэг бүрийн үнэ	Нийт үнэ
Бичиг хэрэг бусад зардал							
1	1	Анонс	Хаяг, сурталчилгааны	м2	4*6	7000	168000
	2	Принтерийн хор		ш	3	45000	135000
	3	Бичгийн цаас		боодол	4	10000	40000
	4	Урьдчилан сэргийлэх тараах материал	Үер, усны аюулаас	ш	1000	250	250000
			Халдварт өвчнөөс	ш	1000	250	250000
			Газар хөдлөлтөөс	ш	1000	250	250000
			Гал түймрийн аюулаас	ш	1000	250	250000
			Ой, хээрийн түймрээс	ш	1000	250	250000
		Өргөмжлөл	4 байгууллагад 1 ажлын хэсгээс шалгаруулна	ш	4	45000	180000
		ДҮН					**1.773.000**
Хоолны зардал							
2	1	Хоолны зардал	А. Дашням	Өдөр	10	10000	100000
	2		А.Батмөнх	Өдөр	10	10000	100000
	3		Б. Батбаяр	Өдөр	10	10000	100000
	4		Д.Оюунбат	Өдөр	10	10000	100000

	5		Ц. Эрдэнэчимэг	Өдөр	10	10000	100000
	6		Дамбадаржаа	Өдөр	10	10000	100000
	7		Мөнх-од	Өдөр	10	10000	100000
	8		Маралмаа	Өдөр	10	10000	100000
	9		Ц.Гантулга	Өдөр	10	10000	100000
	10		Д.Бат-эрдэнэ.	Өдөр	10	10000	100000
	11		О.Хатантуул	Өдөр	10	10000	100000
	12		Идэрмөнх	Өдөр	10	10000	100000
	13		Д.Мөнхням	Өдөр	10	10000	100000
	14		С.Буян-Аривжих	Өдөр	10	10000	100000
	15		Батням	Өдөр	10	10000	100000
	16		Г.Нацагдорж	Өдөр	10	10000	100000
	17		Ж.Мөнхбаяр	Өдөр	10	10000	100000
	18		Элбэгсайхан	Өдөр	10	10000	100000
	19		Лхагвасүрэн	Өдөр	10	10000	100000
	20		Цэрэндорж	Өдөр	10	10000	100000
	21		Цэцэндалай	Өдөр	10	10000	100000
	22		Соронзонболд	Өдөр	10	10000	100000
	23		Б. Отгонзаяа	Өдөр	10	10000	100000
	24		Ж.Өнөржаргал	Өдөр	10	10000	100000
	25		Э.Нандинцэцэг	Өдөр	10	10000	100000
		ДҮН					**2.500.000**
		Шатахуун					
3	1	Исузу 06-61 УБЯ	4 тонн	км	20км*45л	2020төг*9л	18180
	2	Х. Портер-2 31-63 УНТ	Ой, хээрийн түймэр унтраах	км	20км*18л	1720төг*4л	6880
	3	Газел 48-54 УБС	Аврах ажиллагаа	км	20км*20л	1720 төг*4л	6880
	4	Ниссан сапари 47-28 УНЕ	Гал унтраах	км	20км*28л	2020төг*6л	12120

	5	Киа рио 08-45 УНҮ	Урьдчилан сэргийлэх	км	300км*12л	1750төг*36л	61920
	6	МЕН 84-07 УБЧ	Ой, хээрийн түймэр	км	20км*45л	1720төг*13.5л	23220
	7	Исузу 27-36 УНБ	Гэрэл холбооны машин	км	20км*45л	2020төг*4л	8080
	8	Ниссан X-trial 31-32 УНУ	ажлын хэсэг-1	км	300км*12л	1720төг*36л	61920
	9	тоёота витз 16-15 УНЧ	ажлын хэсэг-2	км	300км*12л	1720төг*36л	61920
	10	тоёота примео 31-12 УНЧ	ажлын хэсэг-3	км	300км*12л	1720төг*36л	61920
	11	тоёота приус 82-77 УНЧ	ажлын хэсэг-4	км	300км*12л	1720төг*36л	61920
	ДҮН						**376.880**
	Нийт дүн						**4,649,880**

Баянгол дүүргийн Засаг даргын
2018 оны 02 дугаар сарын 20-ны өдрийн
А/61 дугаар захирамжийн гуравдугаар хавсралт

НИЙСЛЭЛИЙН ЗАСАГ ДАРГЫН НЭРЭМЖИТ ГАМШГААС ХАМГААЛАХ БЭЛЭН БАЙДЛЫН ҮЗЛЭГ ЗОХИОН БАЙГУУЛАХ УДИРДАМЖ

Нэг. ЗОРИЛГО

1.1. Гамшгаас хамгаалах тухай хууль, Нийслэлийн Засаг даргын 2018 оны А/41, дүгээр захирамжийн хэрэгжилтийг хангах, шалган туслах Нийслэлийн Засаг даргын нэрэмжит "**Гамшгаас хамаалах бэлэн байдлын үзлэг**"-ийг явуулснаар дүүргийн нутаг дэвсгэрт тохиолдож болзошгүй гамшгийн аюулаас хүн, мал амьтан, эд хөрөнгө, хүрээлэн байгаа орчныг урьдчилан сэргийлэх, аврах, хор уршгийг арилгах, хойшлуулшгүй сэргээн босгох үйл ажиллагаанд иргэн, аж ахуйн нэгж, байгууллагын томилгоот бүрэлдэхүүнийг сурган дадлагажуулах, гамшгийн үеийн хүч хэрэгслийн харилцан ажиллагааг сайжруулах, гамшгаас хамгаалах бэлтгэл бэлэн байдалд шалган туслах, бэлтгэл бэлэн байдлыг хангуулахад оршино.

Хоёр. ЗОХИОН БАЙГУУЛАГЧИД

2.1. Нийслэлийн Онцгой байдлын газрын Гамшгийн шуурхай удирдлагын хэлтэс
2.2. Баянгол дүүргийн Онцгой байдлын хэлтэс

Гурав. ҮЗЛЭГ ЯВУУЛАХ ХУГАЦАА, АЖ АХУЙН НЭГЖ, БАЙГУУЛЛАГА

3.1. 2018 оны 03 дугаар сарын 28-наас 03 дугаар сарын 30-ны өдрүүдэд,
3.2. Яам агентлаг, аж ахуй нэгж, боловсролын байгууллага, сургууль, цэцэрлэг, хороо, эмнэлэг, худалдааны төвүүд, зах, төрийн захиргааны байгууллага, ШТС, банк гэх мэт

Дөрөв. ҮЗЛЭГЭЭР

4.1. Гамшгаас хамгаалах төлөвлөгөө боловсруулж батлуулж, төлөвлөгөөнд тодотгол хийсэн эсэх;
4.2. Утас, хаягийн бүртгэлд тодотгол хийсэн эсэх;
4.3.Зарлан мэдээлэл явуулах схемд тодотгол хийсэн эсэх;
4.4.Мэргэжлийн анги томилсон тушаалын огноо, дугаар /хэдэн хүний бүрэлдэхүүнтэй хэдэн төрлийн мэргэжлийн ангийг томилгоожуулсан/ эсэх;
4.5. Гамшгаас хамгаалах ангилалын сургалтыг явуулсан эсэх;
- Удирдах бүрэлдэхүүний
-Мэргэжлийн ангийн, ажилтан албан хаагчдын
4.6. Мэргэжлийн ангийн бүрэлдэхүүнийг шаардлагатай багаж хэрэгслээр хангасан байдал,
4.7. Мэргэжлийн ангийн бүрэлдэхүүнийг нэг бүрийн хамгаалах хэрэгслээр хангасан эсэх;
4.8. Гамшгийн эмзэг байдал эрсдэлийн үнэлгээ хийлгэсэн эсэх;
4.9. Гамшгийн үед шаардлагатай хөрөнгийн эх үүсвэрийг бүрдүлж, зориулалтын дагуу зарцуулсан эсэх;
4.10. Гамшгаас урьдчилан сэргийлэх чиглэлээр сурталчилгаа хийсэн эсэх;

4.11. Гамшгийн аюулыг зарлан мэдээлэх боломж /зарлан мэдээлэх дохиотой эсэх/;
4.12. Барилга обьектын ойролцоох аюулгүй талбайг томилгоожуулж, тэмдэгжүүлсэн эсэх;
4.13. Авралтын зам гарцын схем зураглал хийгдсэн эсэх;
4.14. Зам гарцын тэмдэг тэмдэглэгээ тавигдсан эсэх;
4.15. Цацрагийн үүсгүүр, химийн бодис уусмалын ашиглалт, хадгалалт, хамгаалалт,
4.16. Тэсэрч дэлбэрэх аюултай бодисын ашиглалт, хадгалалт, хамгаалалт,
4.17. Гал унтраах анхан шатны багаж хэрэгслийн хангалт, ашиглалт байгаа эсэх;
4.18. Гамшгаас хамгаалах, галын аюулгүй байдлыг хангуулах чиглэлээр урьд нь явагдсан шалгалтын мөрөөр зохион байгуулсан ажил, зөрчлийг арилгуулсан байдал зэргийн шалгаж үзнэ.

БАЯНГОЛ ДҮҮРГИЙН
ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2018 оны 02 сарын 20 өдөр Дугаар А/62 Улаанбаатар хот

Газар эзэмших эрхийн гэрчилгээ
олгох тухай

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.2, "Газрын тухай" хуулийн 21 дүгээр зүйлийн 21.5.3 дахь заалт, нийслэлийн Засаг даргын 2014 оны 301 дүгээр захирамжийн нэгдүгээр хавсралт дахь Хүүгийн Түмэнбаярт холбогдох хэсэг, Нийслэл дэх Захиргааны хэргийн анхан шатны шүүхийн 2016 оны 11 дүгээр сарын 16-ны өдрийн 364 дүгээр тогтоол, Нийслэл дэх Захиргааны хэргийн анхан шатны шүүхийн 2017 оны 04 дүгээр сарын 20-ны өдрийн 300 дугаар тогтоол, захиргааны хэргийн давж заалдах шатны шүүхийн 2017 оны 06 дугаар сарын 20-ны өдрийн 221/МА2017/0436 дугаар магадлал, Монгол улсын дээд шүүхийн хяналтын шатны захиргааны хэргийн шүүх хуралдааны 2017 оны 09 дүгээр сарын 25-ны өдрийн 316 дугаар тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Баянгол дүүргийн 16 дугаар хорооны Туулын 13-24 тоот хашааны 446 м.кв газрыг гэр бүлийн хамтын хэрэгцээний зориулалтаар иргэн Д.Мөнхбатад эзэмшүүлсүгэй.

2. Д.Мөнхбатад газар эзэмших эрхийн гэрчилгээ олгож гэрээ байгуулахыг Газрын алба /Г.Мөнхбаатар/-нд даалгасугай.

ЗАСАГ ДАРГА С.ОДОНТУЯА

D:\ 2018 он\Захирамжлалын ББ\Захирамж.docx

1160200124